



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 335,436,733.00 (гурван зуун гучин таван сая дөрвөн зуун гучин зургаан мянга долоон зуун гучин гурван ) төгрөгийн балансын үнэ, 165,592,565.00 (нэг зуун жаран таван сая таван зуун ерэн хоёр мянга таван зуун жаран таван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг тээврийн хэрэгслийг 1 дүгээр хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.”Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 88,499,400.00 (наян найман сая дөрвөн зуун ерэн есөн мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож 2 дугаар хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Ариунболд, Чингис хааны музейн захирал С.Чулуун, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Ховд дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Энхсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнэ, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3. Автомашинь улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс бүртгэлээс хасаж шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

132001269

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ




Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2021 оны ... дугаар сарын ... өдрийн  
 ... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ, (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг төгрөг	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	2	3	4	5	6	7
1	Ниссан теана, суудлын, 07-74 ОРО арал-1N4AL3AP9EC288945	2014	79,741,650	66,749,021	12,992,629	Чингис хааны музей
2	Ланд круйзер LC-200, суудлын, 06-88УБО, арал-JTMHV05J704257123	2018	255,695,083	98,843,543.68	156,851,539	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
			<b>335,436,733.00</b>	<b>165,592,565.00</b>	<b>169,844,168.00</b>	
	<b>Нийт дүн</b>		(гурван зуун гучин таван сая дөрвөн зуун гучин зургаан мянга долоон зуун гучин гурав)	(нэг зуун жаран таван сая таван зуун ерэн хоёр мянга таван зуун жаран тав)	(нэг зуун жаран есөн сая найман зуун дөчин дөрвөн мянга нэг зуун жаран найм)	





**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа (жил)
1	Хьюндай каунти, автобус, 45-19 ОРО	2011	88,499,400.00	"Ховдын дулааны станц" ТӨХК	8,000,000.00	1
	<b>Нийт дүн</b>		<b>88,499,400.00</b>		<b>8,000,000.00</b>	<b>(найман сая)</b>